



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор Г  
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам”-д дор дурьдсан нэмэлтийг оруулсугай.

1.1. Журмын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийн орлого, даатгуулагчийн тоо” хүснэгт, 8 дугаар хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн нөхөн төлбөр, нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо” хүснэгт, 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” хүснэгт, 12 дугаар хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” хүснэгт, 13 дугаар хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн нэхэмжилсэн хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” хүснэгт, 14 дүгээр хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн учирч болзошгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” хүснэгт, 24 дүгээр хавсралтаар батлагдсан “Давхар даатгалын компанийн дэлгэрэнгүй мэдээллийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан” хүснэгт, 27 дугаар хавсралтаар батлагдсан “Даатгалын зуучлагч компанийн зуучилсан даатгалын үнэлгээ, зуучилсан даатгалын хураамж, зуучлалын орлого” хүснэгт, 29 дүгээр хавсралтаар батлагдсан “Даатгалын хохирол үнэлэгч компанийн хохирол үнэлгээний тоо, үнэлсэн хохирлын хэмжээ, үнэлгээний орлого” хүснэгтийн даатгалын хэлбэр гэсний 1.12-т тус тус “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” гэж нэмэх,

001488

1.2. Журмын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Ердийн даатгалын компанийн даатгасан даатгалын зүйлийн тоо” хүснэгтийн 2 дугаар мөрөнд жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан жолоочийн тоо гэсний дараа “үүнээс албан журмын даатгалд хамрагдсан жолоочийн тоо” гэж нэмэх,

1.3 Журмын 10 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн эхний багананд сайн дурын даатгал, албан журмын даатгал гэж нэмэх. Тус хавсралтын А багананд сайн дурын даатгал, албан журмын даатгал тус бүрд хамааруулан орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан, нэхэмжилсэн хохирлын нөөц сан, учирч болзошгүй хохирлын нөөц сан гэж тус тус нэмэх,

2. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН